

10th
ANNIVERSARY



BOGD BANK
JOINT STOCK COMPANY

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН 2025 ХУРЛЫН МАТЕРИАЛ

IKH BOGD MOUNTAIN

3957m

Mongolia, Bayankhongor



www.bogdbank.com



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Огноо: 2025.02.20

№ 25/18

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйл, 62 дугаар зүйлийн 62.1.7, 62.1.9, 62.1.13, 62.1.15, 62.1.16, 65 дугаар зүйл, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12-р сарын 14-ний өдрийн №377 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02-р сарын 20-ны өдрийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. Богд банкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал /цаашид “Хурал” гэх/-ыг 2025 оны 04-р сарын 03-ны өдөр 09:00 цагт “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн AGM веб суурьтай аппликейшныг ашиглан цахим хэлбэрээр хуралдуулсугай.
2. Ээлжит хурал зарлах тухай мэдэгдлийг 2025 оны 02-р сарын 21-ний өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал /Г.Саруул/-д даалгасугай.
3. Ээлжит хурал хуралдуулах тухай зар мэдээг компанийн болон Хөрөнгийн биржийн цахим хуудас, өдөр тутмын хоёр сонингоор дамжуулан 2025 оны 02-р сарын 24-ний өдөр, 03-р сарын 11-ний өдөр тус тус мэдээлэх ажлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
4. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 03-р сарын 12-ны өдрөөр тогтоосугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:
 - 5.1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах;
 - 5.2. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
 - 5.3. Ногдол ашиг хуваарилалтын талаарх товч танилцуулга;
 - 5.4. Компанийн ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны тайлантай танилцаж батлах;
 - 5.5. Компанийн ТУЗ-н гишүүдийг сонгох;
 - 5.6. Компанийн ТУЗ-ийн 2025 оны төсвийг батлах;
6. Ээлжит хурлын хэлэлцэх асуудлаар гаргах хурлын шийдвэрийн төсөл, тэдгээрийн танилцуулга, саналын хуудас зэрэг хувьцаа эзэмшигч нарт хүргэх хурлын материалыг 2025 оны 02-р сарын 28-ны өдөрт багтаан бэлтгэх, үнэт цаасны брокер дилерийн компанид хүргүүлж хувьцаа эзэмшигчдээс хурлын материалтай ажлын өдрийн 10:00-17:00 цагийн хооронд ирж танилцах боломж бүрдүүлж ажиллахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

7. Ээлжит хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.
- Комиссын дарга: С.Дөлгөөн
Комиссын гишүүн: Э.Пүрэвжаргал
Комиссын гишүүн: Г.Энхжин
8. Хурал зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:
Хурал зохион байгуулах комиссын дарга: Б.Нармандах /Хуулийн хэлтсийн захирал/
Гишүүд: М.Дэлгэрмөрөн /ТУЗ-н нарийн бичгийн дарга/
Гишүүд: Б.Урангоо /Хуульч/
Гишүүд: М.Хүдэрчулуун /Маркетингийн хэлтсийн захирал/
Гишүүд: Г.Мөнхтулга /Маркетингийн ахлах мэргэжилтэн/
Гишүүд: И.Уранцэцэг /Хүний нөөцийн мэргэжилтэн/
9. “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар”-ыг нэгдүгээр, “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг”-ийг хоёрдугаар, хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотойгоор “Хувьцаа эзэмшигчид танилцуулах баримт бичгийн жагсаалт”-ыг гуравдугаар, хувьцаа эзэмшигчдээс санал авах “Саналын хуудас”-ыг дөрөвдүгээр, “ТУЗ-н гишүүдийг сонгох саналын хуудас”-ыг тавдугаар, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах шийдвэрийн төслүүдийг саналын хуудасны хавсралтаар тус тус баталсугай.
10. Хуралд оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчийг саналаа урьдчилан өгөх боломжоор хангаж “БиДиСек ҮЦК” ХК-ийн Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө 27/1, Төв байр хаягаар, Богд банкны Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж 3, Бодь цамхаг, 4 дүгээр давхар хаягаар тус тус дамжуулан авах ба саналын хуудсыг хүлээн авах сүүлийн хугацааг 2025 оны 03-р сарын 27-ны өдрийн 17:00 цаг байхаар тогтоосугай.
11. Хурлын даргаар Богд банкны ТУЗ-ийн дарга /Л.Болдхуяг/-ыг томилсугай.
12. Хурлын шийдвэр, хурлын материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу 2025 оны 04-р сарын 08-ны өдөрт багтаан Монголбанк, Монголын Хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд тус тус хүргүүлэхийг хурал зохион байгуулах комиссын дарга /Б.Нармандах/-д үүрэг болгосугай.
13. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын газар /Д.Төрмандах/-т даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.БОЛДХУЯГ

Богд Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн
2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн
№25/18 тоот тогтоолын нэгдүгээр хавсралт



БОГД БАНКНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

Компанийн нэр: “Богд Банк” ХК

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бодь цамхаг

Хурал хуралдах огноо, цаг, газар: 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 09:00 цагт болно.

Хурал зохион байгуулах хэлбэр: “Би Ди Сек ҮЦК” ХК-ийн AGM веб суурьтай аппликейшныг ашиглан цахимаар хуралдана.

Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр: 2025 оны 03-р сарын 12-ны өдөр

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах;
2. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
3. Ногдол ашиг хуваарилалтын талаарх товч танилцуулга;
4. Компанийн ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны тайлантай танилцаж батлах;
5. Компанийн ТУЗ-н гишүүдийг сонгох;
6. Компанийн ТУЗ-ийн 2025 оны төсвийг батлах;

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбоотой баримт бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг:

Ээлжит хурлаас гарах шийдвэрийн төсөл, тэдгээрийн танилцуулга, саналын хуудас зэрэг хувьцаа эзэмшигч нарт хүргэх хурлын материалыг 2025 оны 02-р сарын 28-ны өдөрт багтаан бэлтгэж үнэт цаасны брокер дилерийн компаниудад хүргүүлнэ.

Хувьцаа эзэмшигч та 2025 оны 04-р сарын 02-ны өдрийн 17:00 цагаас өмнө ажлын өдрүүдэд 10:00-17:00 цагийн хооронд өөрт тохиромжтой дараах газруудын аль нэгт эсхүл <https://www.bogdbank.com/> цахим хуудсаар хурлын материалтай танилцах боломжтой.

- Өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компани;
- “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн төв байр, Хаяг: Залуучуудын өргөн чөлөө 27/1, 8-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот;
- Богд Банкны төв байр буюу Чингэлтэй дүүрэг 1-р хороо, Жигжиджавын гудамж 3, Бодь цамхаг, 4 дүгээр давхарт ирж хурал зохион байгуулах комиссын гишүүн Б.Урангоо /Утас: 8090-8491/-д мэдэгдэн хурлын баримт бичигтэй танилцах боломжтой.

Хуралд оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдийн саналыг урьдчилан өгөх боломжоор хангаж БиДиСЕК ҮЦК ХК-ийн төв байр, Хаяг: Залуучуудын өргөн чөлөө 27/1, 8-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот хаягаар, Богд банкны төв байр буюу Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж 3, Бодь цамхаг, 4 дүгээр давхар хаягаар тус тус дамжуулан авах ба саналын хуудсыг авах сүүлийн хугацаа 2025 оны 03-р сарын 27-ны өдрийн 17:00 цаг байна.

Холбоо барих: 7577-1199, 8090-8491,

И-мэйл хаяг: info@bogdbank.com, broker@bdsec.mn

Хурал зохион байгуулах комисс-той доорхи хаягаар холбоо барина уу:

Гишүүн: Б.Урангоо
Email: urangoob@bogdbank.com
Утас: 9080-8491

Богд банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн
2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн
№25/18 тоот тогтоолын хоёрдугаар дугаар хавсралт



**БОГД БАНКНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ**

Хурал 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 09:00 цагт “Би Ди Сек ҮЦК” ХК-ийн AGM веб суурьтай аппликейшныг ашиглан цахимаар эхэлнэ.

№	Хэлэлцэх асуудал	Хугацаа	Хариуцан танилцуулагч
1	Хурал болох өдрөөс өмнө саналаа ирүүлсэн Хувьцаа эзэмшигчид болон хуралд оролцож буй Хувьцаа эзэмшигчдийг бүртгэж хурлын ирцийн талаар тооллогын комиссын шийдвэр гаргаж хурлын дарга болон хуралд оролцож буй Хувьцаа эзэмшигч нарт танилцуулах	09:00-09:10	Тооллогын комисс
2	Хурлын дарга хурлыг нээж хурлын дэгийг танилцуулах	09:10-09:15	Хурлын дарга
3	Хэлэлцэх асуудлын дагуу дараах асуудлуудыг хэлэлцүүлнэ. Үүнд: 1.1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах; 1.2. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах; 1.3. Ногдол ашиг хуваарилалтын талаарх товч танилцуулга; 1.4. Компанийн ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны тайлантай танилцаж батлах; 1.5. Компанийн ТУЗ-н гишүүдийг сонгох; 1.6. Компанийн ТУЗ-ийн 2025 оны төсвийг батлах;	09:15-10:15	Гүйцэтгэх захирал
5	Хэлэлцэж буй асуудлуудтай холбогдсон асуулт, хариулт	10:15-10:25	Хуралд оролцогсод
6	Хурлаас гарах шийдвэрийн төсөл бүрийг танилцуулах	10:25-10:30	Хурлын дарга
7	Хурлаас гарах шийдвэрийн төсөлтэй холбогдсон асуулт, хариулт	10:30-10:40	Хуралд оролцогсод
8	Хуралд оролцож буй Хувьцаа эзэмшигчид болон Хувьцаа эзэмшигчдийг төлөөлөн оролцогчдоос хурлаас гарах шийдвэрт өгөх саналаа тусгасан саналын хуудсыг хүлээн авах	10:40-10:50	Тооллогын комисс

9	Завсарлага	10:50-11:10	Хурал зохион байгуулах комисс
10	Хуралд оролцож буй Хувьцаа эзэмшигчид болон Хувьцаа эзэмшигчдийг төлөөлөн оролцогчдоос хурлаас гарах шийдвэрт өгөх саналыг хурлаас гарах шийдвэр бүрээр нэгтгэх	11:10-11:30	Тооллогын комисс
11	Хурлаас гарах шийдвэрийн төсөлд саналын хуудсаар саналаа ирүүлсэн Хувьцаа эзэмшигчдийн саналыг тоолж хурлаас гарах шийдвэр бүрээр нэгтгэх	11:30-11:40	Тооллогын комисс
12	Хурлаас гарах шийдвэр бүрээр нэгтгэсэн Хувьцаа эзэмшигчдийн саналын дүнг тооллогын комиссын тогтоол болгон гаргах.	11:40-12:00	Тооллогын комисс
13	Тооллогын комиссын тогтоолыг үндэслэн хурлаас гарах тогтоолыг боловсруулах	12:00-12:10	Тооллогын комисс
14	Хурлаас гарах шийдвэр бүрээр нэгтгэсэн Хувьцаа эзэмшигчдийн саналын дүнгээр гарсан тооллогын комиссын тогтоолыг танилцуулах	12:10-12:20	Тооллогын комисс
15	Хурлаас гарах шийдвэрийг танилцуулах	12:20-12:30	Хурлын дарга
16	Хурлыг хаах	12:30	Хурлын дарга

Богд банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн
2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн
№25/18 тоот тогтоолын гуравдугаар хавсралт



**БОГД БАНКНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД ТАНИЛЦУУЛАХ
БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн №25/18 тоот тогтоол;
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар;
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг;
4. Компанийн 2024 оны бизнесийн үйл ажиллагааны болон санхүүгийн үзүүлэлтүүд;
5. Компанийн 2024 оны санхүүгийн аудитлагдсан тайлан;
6. Компанийн 2024 оны бизнесийн үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-с гаргасан дүгнэлт;
7. Компанийн ТУЗ-н 2024 оны үйл ажиллагааны тайлан;
8. Ногдол ашиг хуваарилах тухай №25/17 тоот тогтоол;
9. ТУЗ-н гишүүдийн танилцуулга;
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах шийдвэрийн төслүүд;
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлаар гаргах шийдвэрийн төсөлд ХЭ-ээс санал өгөх саналын хуудас.

Компанийн тухай хуулийн 65.6-д заасан заалттай холбогдуулан хувьцаа эзэмшигч та бүхэнд танилцуулах зорилгоор дараах зүйлсийг компанийн вэб хуудас болох <https://www.bogdbank.com/> хаягт байршуулсан тул та бүхнийг эдгээр материалтай танилцахыг хүсч байна. Үүнд:

1. Компанийн 2024 оны санхүүгийн тайлан;
2. Компанийн 2024 оны бизнесийн үйл ажиллагааны тайлан;
3. Компанийн 2024 оны санхүүгийн тайлангийн талаарх хараат бус аудитын байгууллагын дүгнэлт;
4. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны ажлын тайлан
5. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн товч танилцуулга;
6. Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, тэдгээрийн эзэмшлийн хувьцааны төрөл, тоо;
7. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн төсөв;

Дээр дурдсан баримт бичиг нь 2025 оны 02-р сарын 28-ны өдрийн дотор бэлэн болсон байна.

oooOooo

Богд Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн
2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн
№25/18 тоот тогтоолын дөрөвдүгээр хавсралт



**БОГД БАНКНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ
АСУУДЛААР ХУРЛААС ГАРАХ ШИЙДВЭРИЙН ТӨСӨЛД ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДЭЭС САНАЛ АВАХ ХУУДАС**

1. Хувьцаа эзэмшигчийн нэр:
2. Регистрийн дугаар:
3. Эзэмшиж байгаа хувьцааны төрөл: Энгийн
4. Эзэмшиж буй хувьцааны тоо: ширхэг
5. Үнэт цаасны компани дахь бүртгэлийн дугаар:
6. Бүртгэсэн ҮЦК-ийн нэр:
7. Брокерын овог нэр:

№	Хэлэлцэж, батлах асуудлууд	Тухайн асуудлаар гарах шийдвэрийн төсөл	Зөвшөөр сөн	Түдгэлзсэн	Татгалзсан	Татгалзсан бол таны өгөх санал
1	Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах	Хурлын материалд байгаа ХЭ-ийн ээлжит хурлаас гарах нэгдүгээр дүгээр шийдвэрийн төсөл				
2	Компанийн ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны тайланг батлах	Хурлын материалд байгаа ХЭ-ийн ээлжит хурлаас гарах хоёр дугаар шийдвэрийн төсөл				
3	Компанийн ТУЗ-ийн 2025 оны төсвийг батлах	Хурлын материалд байгаа ХЭ-ийн ээлжит хурлаас гарах гуравдугаар шийдвэрийн төсөл				

Хувьцаа эзэмшигчийн бөглөх хэсэг	
Хувьцаа эзэмшигч хувь хүний бөглөх хэсэг	Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн бөглөх хэсэг
Хувьцаа эзэмшигч иргэний овог, нэр	Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн нэр
Гарын үсэг.....	Улсын бүртгэлийн дугаар.....

Богд Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн
2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн
№25/18 тогтоолын тавдугаар хавсралт



**БОГД БАНКНЫ
ТУЗ-Н ГИШҮҮНИЙГ СОНГОХ САНАЛ АВАХ ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овогнэр.....

Регистрийн дугаар эсвэл иргэний бүртгэлийн дугаар

Эзэмшиж буй хувьцааны төрөл: Энгийн Тоо:

Бүртгэсэн / Үнэт цаасны компани /

Брокерийн овог: нэр:

Богд банкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 09:00 цагт “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн AGM веб суурьтай аппликейшнийг ашиглан цахим хэлбэрээр зохион байгуулагдана.

Дараах хэлэлцэх асуудалд КУМУЛЯТИВ АРГААР санал хураана.

№	ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ: Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох	Хурлаас гарах шийдвэрийн төсөл	Нэр дэвшигчид өгөх саналын тоо
1	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигч		
1.1		Саналын хуудасны хавсралт	
1.2		Саналын хуудасны хавсралт	
1.3		Саналын хуудасны хавсралт	
1.4		Саналын хуудасны хавсралт	
1.5		Саналын хуудасны хавсралт	
1.6		Саналын хуудасны хавсралт	
2	ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч		
2.1		Саналын хуудасны хавсралт	
2.2		Саналын хуудасны хавсралт	
2.3		Саналын хуудасны хавсралт	

Санал өгсөн хувьцаа эзэмшигч:/ /

Саналын хуудас хүлээн авсан: /Гарын үсэг, тэмдэг/ /

2025 оны ____ сарын ____ өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцсон тооллогын комиссын
дарга:...../Гарын үсэг/...../

Гишүүн:/...../

Гишүүн:/...../

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон
шалтгаан.....

Саналын хуудсыг бөглөх санамж:

Саналыг кумулятив аргаар тоолох асуудалд:

- ТУЗ-ийн гишүүдэд санал өгөхдөө кумулятив аргаар санал хураана.
- Хувьцааны нэгж тутамд ТУЗ-ийн гишүүнийг сонгох 1 саналын эрх байна. Хувьцаа эзэмшигч саналын эрхээ ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшиж буй нэг нэр дэвшигчид бүгдийг эсхүл хэд хэдэн нэр дэвшигчид хуваан өгөх эрхтэй.

Жишээ нь: Хувьцаа эзэмшигч А нь нэр бүхий компанийн 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг. Тус компанийн дүрмээр ТУЗ нь 9 гишүүнтэй, үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоожээ. Хувьцаа эзэмшигч нь А-ийн 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй болно.

- Хувилбар А: Хувьцаа эзэмшигч А нийт 900 саналын эрхээ бүгдийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон нэг нэр дэвшигчид өгч болно.
- Хувилбар Б: Хувьцаа эзэмшигч А нийт 900 саналын эрхийн 600 эрхээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 эрхээ хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус өгч болно. Хувьцаа эзэмшигч А саналын эрхээ ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон хэд хэдэн нэр дэвшигчид дурын харьцаагаар хуваарилан өгөх эрхтэй.

АГУУЛГА

- Богд банкны 2024 оны онцлох үйл явдал
- Онцлох бүтээгдэхүүн, үйлчилгээ
- Дижитал шилжилт
- Олон улсын хөрөнгө оруулалт
- Санхүүгийн голлох үзүүлэлтүүд
- Удирдлагын багийн гишүүд
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд
- ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны тайлан
- ТУЗ-д нэр дэвшигчдийн танилцуулга
- Ногдол ашгийн мэдээлэл

БОГД БАНКНЫ 2024 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



1.

Өнгөрсөн 2024 онд Богд банк үүсгэн байгуулагдсаны 10 жилийн ойн баяр, мөн Монголын банкны салбар үүсэж бэхэжсэний 100 жил давхцсан онцгой жил тохиолоо.



2.

Банкны ажилтнуудын эрүүл мэнд, идэвхтэй дасгал хөдөлгөөнийг дэмжих зорилгоор "Прайм" фитнесс 2024.01 сард нээлт хийсэн. Мөн амралт,чөлөөт цаг, сурч боловсрох, өдөрлөг арга хэмжээ хийх зорилгоор бүрэн тоног төхөөрөмж бүхий "Прайм" танхимыг 2024.01 сард ашиглалтанд оруулсан.



3.

2024 онд нийт 2 удаа 7.27 тэрбум төгрөгийг нийт хувьцаа эзэмшигчиддээ ноогдол ашгийг хуваарилсан.



4.

Богд банкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024.04.29-ний өдөр зохион байгуулж, хувьцаа эзэмшигч нарт санхүү, үйл ажиллагааны тайлангаа танилцуулсан.

БОГД БАНКНЫ 2024 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



5.

Богд банк 2024 онд "Оргил" болон "Ривер" 2 салбарыг шинээр нээж, Хан-Уул дүүргийн харилцагч нартаа бүтээгдэхүүн, үйлчилгээгээ улам ойртуулсан.



6.

Олон улсын үнэлгээний "Moody's" агентлаг 2024 оны 11-р сарын 19-ний өдөр Богд Банкны зээлжих зэрэглэлийг "B3"-аас "B2" буюу тогтвортой эерэг гэж үнэлсэн.



7.

Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг "Дэлхийн хуримтлалын өдөр"-ийн аянд гуравдугаар байранд шалгарлаа. Тус аянд 4 жил дараалан аянд шагналт байранд шалгарсан амжилтыг үзүүлээ.




8.

2024 онд ОУ-ын банк санхүүгийн байгууллагаас 49.07 сая ам долларын урт хугацаат эх үүсвэр шинээр татан төвлөрүүлж, жижиг дунд бизнесийг тэр дундаа эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих, эрчим хүчний хэмнэлттэй үйл ажиллагаа болон хэрэглээг санхүүжүүлэхэд зориулахаар ажиллаж байна.


ОНЦЛОХ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ




Ирээдүйн ИТГЭЛ-тэй иргэддээ зориулж Богд банкнаас хүүхдийн мөнгөн тэтгэмж авдаг дансаа манай банкаар сонговол буцаан олголт авах урамшууллыг зарласан.



Хятад улсын нутаг дэвсгэрийн нийт 600 гаруй хотын хаана ч та Богд банкны ЮнионПэй картаа ашиглан буцаан олголт авах урамшуулалт аяныг зарласан.



Их хотын түгжрэлийг бууруулах, хүссэн газраа түргэн шуурхай очиход туслах ухаалаг шийдлүүдийн нэг болсон их хотын эко унаа "Тара" дугуй болон скүүтер унахдаа хэтэвчээ Богд банкаар цэнэглээд 50%-ийн буцаан олголттой урамшууллыг нэвтрүүлсэн.



Mobile Legends: Bang Bang тоглогчдод зориулсан Mobile Legends карт-ыг Монголд анх удаа танилцуулж байна. Энэ карт нь санхүүгийн ухаалаг шийдэл, цахим спортын ертөнцөд шинэ түвшний боломжуудыг хослуулсан бүтээгдэхүүн юм.

ОНЦЛОХ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ




Харилцагч заавал салбарт ирэх шаардлагагүйгээр онлайнаар харилцагч болох боломжийг болсон.



2024 онд Монголбанк, Үнэт цаас санхүүжилтийн корпораци, Монголын ипотекийн корпораци, Батлан даалтын сан, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамтай хамтран төслийн зээлийн бүтээгдэхүүн гаргах, гэрээ хэлцэл хийх, зээлийн эх үүсвэр болон хүүгийн дэмжлэг авах, тайлан тооцоо нийлэх ажлаар амжилттай хамтран ажиллаж байна.

Шинээр нэвтрүүлсэн төслийн зээлийн бүтээгдэхүүн:

- Аялал жуулчлалын салбарыг дэмжих төслийн зээл
- Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн дэмжих эргэлтийн хөрөнгийн зээл
- Хоршооны гишүүн малчны зээл
- Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн дэмжих хөрөнгө оруулалт зээл
- 2024 онд Засгийн газраас хэрэгжүүлж буй Ноолуур бэлтгэлийн зээл



Compass Card эзэмшигчдэд зориулсан сар бүрийн нэвтрүүлэг арга хэмжээг жилийн хугацаанд тогтмол зохион байгуулж залууст боловсрол, санхүү, амьдралын хэв маягт нь хэрэгцээт сэдвийн хүрээнд 5000 гаруй залуусд санхүүгийн боловсрол түгээсэн.




Богд банк нь Тогтвортой санхүүжилтийн хүрээнд байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлж, зээл олголтод Байгаль орчин нийгмийн эрсдэлийн үнэлгээг тогтмол хэрэгжүүлж байна. Бид харилцагчдадаа "НОГООН" тодорхойлолттой дараах зээлийн бүтээгдэхүүнүүдийг нэвтрүүлэн санхүүжилт олгож байна.

- Эко автомашины зээл
- Ногоон хэрэглээний зээл
- Дулаалгын зээл
- Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зээл

ДИЖИТАЛ ШИЛЖИЛТ

Fintech шийдлүүд нь Богд банкны салшгүй нэг хэсэг бөгөөд өрсөлдөгчдөөсөө ялгарч, хурдацтай өсөлтөд хүрэх боломжийг олгодог.

ДИЖИТАЛ ГҮЙЛГЭЭНИЙ ӨСӨЛТ



ДИЖИТАЛ БҮТЭЭГДЭХҮҮН

Онлайн шуурхай зээл:



Бусад онлайн зээлийн бүтээгдэхүүн:

- Онлайн ПОС-н орлого барьцаалсан зээл
- Онлайн цалингийн зээл
- Онлайн хадгаламж барьцаалсан зээл

ДАВУУ ТАЛ:

- 24/7 үйлчилгээ авах боломж
- Хамгийн бага үйл ажиллагааны зардал - хамгийн бага хураамжтай байх боломж
- Өндөр хадгаламжийн хүү болон сонголттой хадгаламжийн төрлүүд
- Банкны бүх төрлийн үйлчилгээг апп-р авах боломжтой.

МЕТА


(Виртуал банкны салбар)



ДИЖИТАЛ ШИЛЖИЛТ

AI (хиймэл оюун ухаан):

Богд банк нь виртуал туслах хөгжүүлж байгаа. AI туслах нь үйл ажиллагааг сайжруулах харилцагчид түргэн шуурхай банкны бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлэх зорилготой.



ТӨЛБӨРИЙН ШИЙДЛҮҮД:

Богд банк нь Qraу гүйлгээний шийдэл, Богд хэтэвч болон олон улсын мөнгөн гүйлгээний шилжүүлэг хийх боломжийг Богд банкны Аппликэйшнд нэвтрүүлсэн.



ХУВИЙН ТОХИРГОО:

Харилцагч нь өөрийн амьдралын хэв маягт тохируулан Богд банкны аппликэйшний хувийн тохиргоог удирдах боломжтой ба гүйлгээний лимитийг тохируулах, өнгө төрхийг солих гэх мэт олон үйлчилгээг авах боломжтой.



НОГООН САНХҮҮЖИЛТ:

Ногоон санхүүжилтийг дэмжих үүднээс харилцагчийн үйлчилгээ үзүүлэх гэрээг онлайн хэлбэрт хадгалдаг болсон.

ЗОРИЛТОТ САЛБАРУУД

Богд банк нь Монгол Улсын ирээдүйг илүү сайхнаар цогцлоон, бизнесийн бүхий л салбарт тогтвортой хөгжлийг дэмжихийн төлөө зүтгэж байна.

- Зээлийн багцын 32 гаруй хувь нь ЖДҮ бизнес, ЖДҮ-ийн үйлчлүүлэгчдийн баазыг нэмэгдүүлж, төрөл бүрийн салбарт дотоодын бизнесийг дэмжихийг эрмэлздэг.
- Богд банк ЖДҮ-ийн салбарыг гол сегментээ болгон зорилго, зорилтоо тодорхойлж байна
- Тогтвортой өсөлтийг дэмжигч Богд банк үр дүнтэй ногоон төслүүдийг үргэлжлүүлэн санхүүжүүлэх болно
- Богд банк нь уул уурхай зэрэг байгальд хор хөнөөл учруулдаг үйлдвэрүүд, харилцагчидтай хамтран ажилладаггүй

ЖДҮ САНХҮҮЖИЛТ

НОГООН САНХҮҮЖИЛТ

Зорилтот сегмент

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ ДЭМЖИХ

ХӨДӨӨ ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ

- Богд банкны ЖДҮ эрхлэгчдийн 48 хувь нь эмэгтэйчүүд тэргүүтэй бизнес эрхлэгчид байдаг
- Богд банк шударга өсөлтийг дэмжихийн тулд эмэгтэйчүүд давамгайлсан бизнесүүдийг дэмжсээр байх болно
- Богд банкны ажилчдын 66 орчим хувь нь эмэгтэйчүүд байдаг
- Богд банк хөдөө аж ахуйн бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор хөдөө орон нутагт үзүүлэх үйлчилгээгээ өргөжүүлэх зорилготой
- Богд банк Монгол Улсын нийт 21 аймагт үйл ажиллагаагаа өргөжүүлэх төлөвлөгөөг хэрэгжүүлж байна.

ОЛОН УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИД


Богд банк нь олон тооны Хөгжлийн санхүүгийн байгууллагууд (ХСБ) болон нөлөө бүхий зээл олгогчдоос ЖДҮ-ийн зээл, ногоон зээлд тусгайлан зориулсан санхүүжилтүүдийг амжилттай авч чадсан.

- Эмэгтэй бизнес эрхлэгчдийг болон ногоон санхүүжилтийг дэмжих зорилгоор 2022 оны 12-р сард АНУ-ын Олон улсын хөгжлийн санхүүжилтийн корпораци (DFC) –с 15 сая ам. доллар татсан. (2022 оны 12-р сар)
- Эмэгтэй жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор DGGF (Dutch Good Growth Fund)–с 8 сая ам. долларын санхүүжилтийг татсан. (2023 оны 12-р сар)
- Жижиг, дунд бизнесийг дэмжих зорилгоор Enabling Capital хөрөнгө оруулалтын сангаас (EMF Microfinance Fund, AgmvK (EMF)) 17 сая ам. долларын санхүүжилт татсан.
- Бичил, жижиг, дунд бизнесийг болон ногоон зээлийг дэмжих зорилгоор Азийн Хөгжлийн Банкнаас 15 сая ам. доллар татсан.
- Жижиг, дунд бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зорилгоор GGSF (Global Gender-Smart Fund)–с 8 сая ам. долларын санхүүжилтийг татсан.
- Нидерландын Хөгжлийн Агентлаг (FMO)-тай жижиг, дунд үйлдвэрлэл болон ногоон төслүүдийг дэмжих 20 сая ам.долларын санхүүжилтийн гэрээ байгуулж, стратегийн хамтын ажиллагаагаа эхлүүллээ.




ОЛОН УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИД

ЖДҮ-ИЙН ЗЭЭЛИЙН СЕКТОР (2024 4-Р УЛИРАЛ)



- ЖДҮ-ийн нийт зээлийн багцын 74 гаруй хувийг худалдаа, үйлчилгээ, санхүүгийн үйлчилгээ бүрдүүлж байна

БИЧИЛ, ЖИЖИГ ДУНД ЗЭЭЛ (2024 4-Р УЛИРАЛ)



- ЖДҮ-зээлийн багцын 27% (51.1 тэрбум)-ийг бичил бизнес эрхлэгчид, 41%-ийг (77.2 тэрбум)-ийг жижиг бизнес эрхлэгчид, 32%-ийг (59.2 тэрбум)-ийг дунд бизнес эрхлэгчид эзэлж байна

БИЗНЕС ЭРХЛЭГЧ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ ДЭМЖИХ

Богд банк нь эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжин ажиллахаар стратеги төлөвлөгөөтэйгөөр ажиллаж байна.

46%


Богд банкны нийт зээлдэгчдийн
46% нь эмэгтэйчүүд

48%

Богд банкны ЖДҮ эрхлэгч
зээлдэгчдийн 48% нь эмэгтэйчүүд

- Богд банк нь эмэгтэй зээлдэгчид болон бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд олгох зээлээ нэмэгдүүлж, нийт багцын 70%, 50%-д хүргэхээр зорин ажиллаж байна.
- Богд банк нь өрхийн үйлдвэрлэлийг дэмжин эдийн засгийн хөгжлийг нэмэгдүүлэн ажиллаж байна. Мөн банк нь хувийн бизнесээ өргөжүүлэн нэмэгдүүлж буй эмэгтэйчүүдийг ЖДҮ эрхлэгч болоход тусалж ажиллаж байна.
- Богд банк нь хувь хүн болон шинэ бизнес эрхлэгчдэд бизнес эрхлэх сургалт оруулж тэдний ур чадварыг нэмэгдүүлэхээр зорьж байна. Энэхүү санаачилгаараа банк нь харилцагчтай урт хугацааны харилцааг бий болгохын зэрэгцээ шинэ бизнесээ хөгжүүлэхэд нь туслах болно.
- Богд банк нь ЖДҮ эрхлэгчдэд баталгаа гаргадаг ашгийн бус байгууллага болох Зээлийн батлан даалтын сантай урт хугацааны түншлэлийн гэрээ байгуулсан. Энэхүү түншлэлийн хүрээнд хоёр тал харилцан ашигтай хамтран ажиллах, тэр дундаа Банкны жижиг, дунд бизнес эрхлэгчдэд үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэхээр тохиролцов.

Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг
сектороор нь ангилвал





БОГД БАНК
ИТГЭЛ ТҮГЭЭНЭ

САНХҮҮГИЙН _____ ...

ТАНИЛЦУУЛГА



www.bogdbank.com


САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

- Нийт хөрөнгө 2024.12.31-ний байдлаар **1,066,504.49 сая төгрөгт** /1 их наяд 66 сая төгрөгт/ хүрч өмнөх жилээс **49.72%**-аар өссөн байна.
- Цэвэр зээлийн багц 2024.12.31 гэхэд **578.15 тэрбум** төгрөгт хүрч өмнөх жилээс **85.21%**-аар өссөн байна.
- Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь буурч **2.23%** -тай болсон байна.
- Харилцах хадгаламж өмнөх оны мөн үеэс **55.70%**-аар өсч **581.32 тэрбум** төгрөгт хүрчээ.
- 2024 онд олон улсын банк болон санхүүгийн байгууллагаас нийт **49.07 сая ам долларын** урт хугацаат эх үүсвэр шинээр татан төвлөрүүлж, жижиг дунд бизнесийг тэр дундаа эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих, эрчим хүчний хэмнэлттэй үйл ажиллагаа болон хэрэглээг санхүүжүүлэхэд зориулахаар ажиллаж байна.
- Тайлант хугацаанд Богд банк нь Банкны тухай хуулиар болон Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажиллалаа. Үүнд:
- Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа **21.20%** (байвал зохих хэмжээ 12.5%). Ийнхүү давуулан биелүүлсэн нөөц өөрийн хөрөнгө нь аливаа болзошгүй эрсдэлийг даахаас гадна ирээдүйд активын тэлэлт хийх, ногдол ашиг тараах боломжийг бий болгодог.
- Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа **30%** (байвал зохих хэмжээ 25.0%) буюу бусдаас татан төвлөрүүлсэн нийт эх үүсвэрийнхээ 31% болох 228.47 тэрбум төгрөгийг бэлэн мөнгө болон бэлэн мөнгөнд түргэн хөрвөх боломжтой Монголбанкны Үнэт цаасанд байршуулан удирдаж байна.



САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2024.12.31-НИЙ БАЙДЛААР



ROA

4.52%



ROE

26.01%



Төлбөр түргэн гүйцэтгэх
чадварын харьцаа

30.42%




Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн
хөрөнгө болон эрсдэлээр
жигнэсэн активын
зохистой харьцаа

21.20%

САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД


НИЙТ ХӨРӨНГӨ, ЦЭВЭР АШИГ

Нийт хөрөнгө (2017-2024, сая төгрөг)



- 2024 оны 4-рулирлаар нийт хөрөнгө 1,066.5 тэрбум төгрөгт хүрсэн байна.
- Нийт хөрөнгийн жилийн нийлмэл өсөлтийн хувь (CAGR) 2017-2024 оны дунджаар 46,28% байна.

Цэвэр ашиг (2017-2024, сая төгрөг)




- 2024 оны эцсээр цэвэр ашиг 40.2 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 42.4% -р өссөн байна.
- Цэвэр ашиг сүүлийн 8-н жилийн мөн үетэй харьцуулахад 61.46%-иар өссөн

САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

НИЙТ ХӨРӨНГӨ, ЦЭВЭР АШИГ


Өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа (2023Q4 vs 2024Q4)



- Богд банк нь өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцааг банкны салбарт хамгийн өндөр түвшинд байлгаж, санхүүгийн хямрал болон бусад урьдчилан тооцоолоогүй алдагдлыг даван туулах чадвараа баталгаажуулдаг.


1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө (2017-2024, in MNT million)

*according to IFRS




- 2024 оны 4-р улирал гэхэд 1 түвшиний нийт хөрөнгө 167.9 тэрбум төгрөгт хүрсэн байна.
- 1-р түвшний нийт хөрөнгийн хэмжээ 2017 оноос 2024 оны эцэс хүртэл CAGR 28,68%-иар өссөн байна.

Төлбөр түргэн гүйцэтгэх харьцаа (2023Q4 vs 2024Q4)




Богд банк нь салбартаа хамгийн өндөр төлбөр түргэн гүйцэтгэх харьцаа үзүүлэлттэй банкнуудын нэг ба чадварлаг, найдвартай үйлчилгээг үргэлжлүүлэн хүргэх болно.

NPL болон Эрсдэлийн сангийн нөөц (2017-2024, сая төгрөг)



Эх үүсвэрийн бүтэц (2018-2024, сая төгрөг)




- Сүүлийн 7 жилийн хугацаанд Богд банк санхүүгийн эх үүсвэрийг төрөлжүүлэн хөгжүүлж чадсан
- 2024 он гэхэд иргэдийн хадгаламж 2023 оны эцсийнхээс 44.15%-аар өссөн байна.
- Харилцах, хадгаламжийн нийлмэл өсөлтийн хувь 2020 оноос 2024 оны дунджаар 35%-тай байна.

САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД


ЗЭЭЛИЙН БАГЦ

Нийт зээл салбараар (2024 4-р улирал, сая төгрөг)



- Нийт зээлийн хэмжээ 2024 оны 4-р улирлын байдлаар 577.8 тэрбум төгрөг болж, манай нийт зээлийн багцын 77 гаруй хувийг жижиглэнгийн болон жижиг дунд үйлдвэрийн зээл эзэлж байна..

Нийт жижиглэнгийн зээл (2024 4-р улирал, сая төгрөг)




- Нийт Жижиглэнгийн зээлийн жилийн нийлмэл асөлтийн хувь 2017 оноос 2024 оны хувьд (CAGR) 112.8% байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2024 онд 139.1% аар өссөн байна.

САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД


ЗЭЭЛИЙН БАГЦ

Нийт байгуулагын зээл (2024 4-р улирал, сая төгрөг)



- Байгууллагын зээлийн нийт багц 2017 оноос 2024 оны эцэс хүртэл жилийн нийлмэл өсөлтөөр (CAGR) 64.8%-иар өсч, 2024 оны эцэст жилийн 74.8%-иар өссөн байна.

Нийт ЖДҮ зээл (2024 4-р улирал, сая төгрөг)



- Нийт ЖДҮ зээлийн жилийн нийлмэл өсөлтийн хувь 2017 оноос 2024 оны хувьд (CAGR) 91.7% байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2024 онд 45.8% аар өссөн байна.


САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ЗЭЭЛИЙН БАГЦ


НИЙТ ЗЭЭЛИЙГ ЭДИЙН ЗАСГИЙН САЛБАРААР АНГИЛВАЛ
(2024 оны 4-р улирал, тэрбум төгрөгөөр)

SECTOR	2024	%
Хөдөө аж ахуй	0.94	0.2%
Үйлдвэрлэл	19.59	3.4%
Худалдаа	64.84	11.2%
Үйлчилгээ	62.83	10.9%
Барилга байгууламж	69.30	12.0%
Тээвэр	11.59	2.0%
Боловсрол, эрүүл мэнд	4.88	1.0%
Ипотекийн зээл	76.40	13.2%
Хэрэглээ	54.24	9.4%
Бусад зээл	213.15	36.9%
Нийт	577.77	100.00%

Нийт зээл, бүтээгдэхүүнээр
(2024 оны 4-р улирал)



Цэвэр зээлийн багц болон Чанаргүй зээлийн харьцаа (2024 оны 4-р улирал, сая төгрөг)




- Зээлийн багцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2024 оны байдлаар 84.83%-р өссөн байна.
- Зээлийн жилийн нийлмэл өсөлтийн хувь (CAGR) 2017 оны 2024 дунджаар 86.48% байна.

САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД


БОГД БАНКИЙГ ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙГ БАНКНЫ САЛБАРТАЙ ХАРЬЦУУЛАХАД

Хөрөнгийн өсөлт




Сүүлийн 6 жилийн байдлаар салбарын активын дундаж өсөлт 10.88%, Богд банкны өсөлт 29.94% байгаа нь салбарын дунджаас 3 дахин өндөр өсөлттэй байгааг харуулж байна.

Зээлийн өсөлт



Богд банкны зээлийн дундаж өсөлт сүүлийн 5 жилд 54.03% байгаа нь салбарын дунджаас 5 дахин өндөр байна.

Хадгаламжийн өсөлт




Хадгаламжийн жилийн өсөлтийн хурд нь банк үйл ажиллагаагаа өргөжүүлж, зах зээлд эзлэх байр сууриа салбарын дунджаас 3 дахин өндөр хурдаар нэмэгдүүлж байгааг харуулж байна.

САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД


БОГД БАНКНЫ ГҮЙЦЭТГЭЛ

Өөрийн хөрөнгийн өгөөж



Сүүлийн 7 жилийн хугацаанд Богд банкны ROE тогтмол өсч, 2024 он гэхэд 26.01%-д хүрчээ.

Хөрөнгийн өгөөж



2024 оны эцсээр манай банкны ROA 4.52%-д хүрсэн ба 2025 оны эцэс гэхэд хамгийн өндөр өгөөжтэй байхаар төлөвлөж байна.

САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Богд Банкны үндсэн үйл ажиллагааны органик өсөлтийн төлөвлөгөө болон гүйцэтгэл.


	Монгол банкны зохистой байдлын харьцаа	2019	2020	2021	2022	2023	2024
Нийт хөрөнгө		248,824	224,901	329,862	478,384	712,324	1,066,504
Нийт эх үүсвэр		194,059	163,600	228,066	361,763	570,710	897,357
Нийт өөрийн хөрөнгө		54,766	61,300	101,797	116,620	141,613	169,147
Цэвэр ашиг		2,923	5,617	10,781	19,056	28,201	40,168
Зээл (цэвэр)		82,332	101,263	147,911	208,605	312,151	578,145
Харилцах хадгаламж		159,042	130,602	165,844	260,590	378,624	569,278
Активийн өгөөж		1.36%	2.38%	3.73%	4.76%	4.91%	4.52%
Өөрийн хөрөнгийн өгөөж		5.48%	9.67%	12.58%	17.58%	22.74%	26.01%
Төлбөр түргэн гүйцэтгэх харьцаа	>25%	54.20%	58.82%	45.20%	39.40%	42.28%	30.42%
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ	>12%	39.45%	41.37%	48.81%	35.71%	28.23%	21.20%

НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

	2022 оны 1-р хагас	2022 оны 2-р хагас	2022 нийт
Цэвэр ашиг /сая ₮/	8,033.40	11,096.40	19,056.48
Хувиарлагдсан ашиг /хувь/	15%	25%	21%
Хувиарлагдсан ашиг /сая ₮/	1,205.03	2,774.10	3,979.12
Хувьцааны тоо ширхэг	62,500,000.00	1,250,000,000.00	1,250,000,000.00
Ноогдол ашиг ₮ /per share/	19.28	2.22	3.18

	2023 оны 1-р хагас	2023 оны 2-р хагас	2023 нийт
Цэвэр ашиг /сая ₮/	15,125.29	13,076.20	28,201.31
Хувиарлагдсан ашиг /хувь/	25%	25%	25%
Хувиарлагдсан ашиг /сая ₮/	3,787.50	3,521.75	7,309.25
Хувьцааны тоо ширхэг	1,250,000,000.00	1,250,000,000.00	1,250,000,000.00
Ноогдол ашиг ₮ /per share/	3.03	2.82	5.85

	2024 оны 1-р хагас	2024 оны 2-р хагас	2024 нийт
Цэвэр ашиг /сая ₮/	15,011.20	25,156.50	40,167.70
Хувиарлагдсан ашиг /хувь/	25%	20%	23%
Хувиарлагдсан ашиг /сая ₮/	3,750.00	5,000.00	8,750.00
Хувьцааны тоо ширхэг	1,250,000,000.00	1,250,000,000.00	1,250,000,000.00
Ноогдол ашиг ₮ /per share/	3.00	4.00	7.00



Богд банк нь хагас жил бүр ногдол ашиг тараадаг анхны банк бөгөөд татварын дараах цэвэр ашгийн 25% ийг хувьцаа эзэмшигч нартаа ногдол ашиг болгон тараах бодлоготой ажилладаг. 2022 онд 3,9 тэрбум төгрөг, 2023 онд 7,3 тэрбум төгрөг, 2024 онд 8,7 тэрбум төгрөгийг тус тус ногдол ашиг болгон бэлэн мөнгө хэлбэрээр олгосон байна. Ингэснээр нийт 3500 орчим хувьцаа эзэмшигч нартаа өнгөрсөн 3 жилийн хугацаанд нийтдээ 20 тэрбум төгрөгийг ногдол ашиг болгон олгосон байна.

УДИРДЛАГЫН БАГ



Ганбаатар САРУУЛ

Гүйцэтгэх захирал



Мөнхжаргал АЛТАНБАГАНА

Бизнес банк хариуцсан дэд захирал



Молонжамц БАТ-ӨЛЗИЙ

Санхүү хариуцсан дэд захирал



Чойноо БАНЧИН

Бизнес хөгжил хариуцсан дэд захирал



Эрдэнэ-Очир ГАН-ЭРДЭНЭ

Хөрөнгө зохицуулалт хариуцсан дэд захирал



Болдхуяг БИЛЭГТ

Байгууллагын банк хариуцсан
дэд захирал



Мөнхням АЛТАНЗҮРХ

Мэдээллийн технологи хариуцсан
дэд захирал



Энхтуяа ЦЭЦЭГДЭЛГЭР

Эрсдэл хариуцсан дэд захирал



БОГД БАНК


ИТГЭЛ ТҮГЭЭНЭ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



www.bogdbank.com

ХУВЬЦААНЫ БҮТЭЦ



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



Лувсанвандан БОЛДХУЯГ

ТУЗ-ийн Дарга, МУ-ын Гавъяат Эдийн Засагч



Ганбаатар САРУУЛ

ТУЗ-ийн гишүүн/Гүйцэтгэх захирал



ЖАН ТОРСТЭН Дазер

ТУЗ-ийн гишүүн



Дэмчигжав МОЛОМЖАМЦ

ТУЗ-ийн гишүүн



Рожер Томас Мойес

ТУЗ-ийн хараат бус гишүүн



Жамбалсүрэн НАРАНТУЯА

ТУЗ-ийн хараат бус гишүүн



Рэнцэндорж БАЯСГАЛАН

ТУЗ-ийн гишүүн



Базарсад ОЙГОНЖАРГАЛ

ТУЗ-ийн гишүүн



Эрдэнэ БЯМБАЖАВ

ТУЗ-ийн хараат бус гишүүн

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, ТАНИЛЦУУЛГА

ТУЗ нь банкны үндсэн чиг хандлагыг тодорхойлж, стратеги, бодлого, зарчмыг батлах ба гүйцэтгэх удирдлагын банкны үйл ажиллагаанд мөрдүүлэх, зохион байгуулах ажлын хэрэгжилтэд хяналт тавин ажилладаг. Мөн түүнчлэн банкны удирдлага, зохион байгуулалтын ерөнхий бүтэц захиргааны зардлын хэмжээг тогтоох, гүйцэтгэх захирлыг Монголбанкны Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр томилох, түүнийг ажлаас түдгэлзүүлэх, чөлөөлөх, түүнтэй байгуулах гэрээний нөхцөл, олгох цалин шагнал урамшуулал, үүрэг хариуцлагын хэмжээг тогтоох, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах, ХЭХ-аар хэлэлцэх асуудал, саналын эрхтэй хувь нийлүүлэгчдийг тодорхойлох, банкны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлж батлуулах зэрэг эрхтэй.

Богд банкны ТУЗ нь 6 ердийн болон 3 хараат бус гишүүдээс бүрдсэн нийт 9 гишүүнтэй. ТУЗ-ийн гишүүд нь Монголбанкнаас тавигдсан шалгуурыг хангасан, банк, санхүүгийн салбарт хамгийн багадаа 15 жил ажилласан туршлагатай байна. ТУЗ-ийн гишүүд нь ТУЗ-ийн дэргэдэх хороодын гишүүнээр ажилладаг. ТУЗ-ийн гишүүд бүрийн бүрэн эрхийн хугацаа дараагийн жилийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах өдрөөр дуусгавар болох бөгөөд гишүүдийг улируулан сонгож болохоор зохицуулсан байна.

2024 онд ТУЗ-ийн цахимаар болон танхимаар хуралдсан 85 удаагийн төлөвлөгөөт болон ээлжит бус хурлыг зохион байгуулж, нийт 152 асуудлаар санал, үндэслэлээ хэлж, хурлын шийдвэрт болон ТУЗ, хороодын хурлын тэмдэглэлд товч тусган ажилласан. Банк нь харилцагчийн эрсдэл, газар зүйн байршил, улс орны эрсдэл, бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэх эрсдэл зэргийг сайтар судлан харилцагч тус бүрийн эрсдэлийг үнэлж ажиллах, урьд хийсэн үнэлгээгээ шинэчлэх арга хэмжээ авахыг гүйцэтгэх удирдлагад даатгахын хамт ТУЗ, хороо уг асуудлыг байнгын анхааралдаа байлгадаг.

ТУЗ, хороод нь банкны бүхий л асуудлаар зохих шийдвэр гаргаж байсны дотор үйл ажиллагааны жил, хагас жилийн үр дүн, тайлан, бизнес төлөвлөгөө, эрсдэлийн аппетит, тогтворжуулалтын төлөвлөгөө, банкны бүтэц, ногдол ашиг хуваах, хөндлөнгийн аудит сонгох, тайланг нь хэлэлцэх, сонирхлын зөрчилтэй зээл, хэлцлийг шийдэх, энэ талаарх журмыг улам сайжруулах, гүйцэтгэх удирдлага, гүйцэтгэх захирлын жил, хагас жилийн ажлыг дүгнэх, банкны үйл ажиллагааны зохистой харьцааны үзүүлэлтүүдийн биелэлт, явц зэрэг чухал асуудлыг шийдэхийн хамт зээл олгох, төлүүлэхтэй холбогдсон шуурхай шийдэх асуудлуудыг цаг алдахгүй хугацаанд нь шийдэж, харилцагчдад шуурхай үйлчилж, банкныхаа үр дүнг нэмэгдүүлэн ажилласан.

ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН

№	Нэр	Эрхэлж байгаа ажил	Томилогдсон	Төлөв
1	Л.Болдхуяг	Богд банкны ТУЗ-ийн дарга	2014.10.31	Ердийн
2	Г.Саруул	ТУЗ гишүүн, Гүйцэтгэх захирал	2014.10.31	Ердийн
3	Ж.Нарантуяа	ОУ-ын Санхүүгийн Корпорацийн зөвлөх	2014.10.31	Хараат бус
4	Э.Бямбажав	"Их тусч" ХХК-ийн захирал	2022.07.06	Хараат бус
5	Рожер Томас Моеэс	FSIP төслийн Финтекийн ахлах зөвлөх	2022.09.14	Хараат бус
6	Д.Моломжамц	ОУ-ын Хөрөнгө Оруулалтын банкны зөвлөх	2018.05.09	Ердийн
7	ЖАН ТОРСТЭН	ТУЗ гишүүн	2018.12.31	Ердийн
8	Б.Ойгонжаргал	Жем Интернэшнл ХХК, Ерөнхийлөгч	2022.07.06	Ердийн
9	Р.Баясгалан	Дэлфос Интернэшнлийн Зөвлөх	2023.04.24	Ердийн

Банкны ТУЗ нь Эрсдэлийн Удирдлага, Аудит болон Нэр дэвшүүлэх, үнэлгээ урамшууллын гэх гурван хорооны үйл ажиллагааг хариуцан удирддаг.

- ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХОРОО
- АУДИТЫН ХОРОО
- НЭР ДЭВШҮҮЛЭХ, ҮНЭЛГЭЭ УРАМШУУЛЛЫН ХОРОО
- ТУЗ-ИЙН АЖЛЫН АЛБА

АУДИТЫН ХОРОО

Аудитын хороо нь компанийн санхүүгийн тайлангийн үйл явц, дотоод хяналтын систем болон санхүүгийн эрсдэлийн менежмент, аудитын үйл явц, комплайнс буюу хуулийн нийцлийн асуудал болон холбогдох хууль тогтоомж, Банкны дотоод дүрэм, журмын дагуу хянахад ТУЗ-д дэмжлэг үзүүлэн ажилладаг. Энэхүү хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Э.Бямбажав, гишүүдээр ТУЗ-ийн дарга Л.Болдхуяг, ТУЗ-ийн гишүүн Д.Моломжамц, ТУЗ-ийн хараат бус гишүүн Ж.Нарантуяа, ТУЗ-ийн хараат бус гишүүн Рожер Томас Моеэс нар ажиллаж байна.

2024 онд Хорооны хурлыг танхимаар болон цахимаар 3 удаа хийж, 5 гаруй асуудлаар санал төсөл боловсруулан хэлэлцэж ТУЗ-өөр шийдүүлсэн.

2024

1.	2024.01.08	24/01	1. ДАГ-ын 2023 оны төлөвлөгөөний гүйцэтгэл
2.	2024.04.15	24/02	1.Богд банкны Дотоод аудитын газрын 2024 оын төлөвлөгөө 2. Банкны 2023 оны тогтворжуулах төлөвлөгөөний гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан
3.	2024.10.15	24/03	1.Хөндлөнгийн аудит сонгох тухай 2.Ажлын явцын мэдээлэл

Хорооны хурлаар “Мөнгө угаах болон терроримыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд чиглэсэн дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөрт” –т аудитын хяналт хийх төлөвлөгөөг хэлэлцэж баталсан. Төлөвлөгөөний дагуу хийсэн аудитын дүнг оны эцсээр хэлэлцэж, энэ асуудлын хүрээнд Богд банкны ажил ямар хэмжээнд байгааг дүгнэж цаашдын чиглэлээ тодорхойлон ДАГ-ын 2024 оны төлөвлөгөөнд тусган ажиллах зорилт тавьж байна.

НЭР ДЭВШҮҮЛЭХ, ҮНЭЛГЭЭ УРАМШУУЛЛЫН ХОРОО

Банкинд мөрдөгдөж буй цалин урамшууллын бодлогын хэрэгжилт, гүйцэтгэх удирдлагын урамшууллын асуудлыг банкны эрхэм зорилго, стратеги төлөвлөгөөний биелэлт, ёс зүйн хэм хэмжээ болон банкны урт хугацааны ашигт ажиллагаатай уялдуулсан эсэхэд хяналт тавих, ТУЗ, гүйцэтгэх удирдлагад олгох цалин урамшууллын хэмжээг тодорхойлж, ТУЗ-ийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааг идэвхжүүлэх үүрэгтэй. Тус хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Ж.Нарантуяа, гишүүдээр ТУЗ-ийн дарга Л.Болдхуяг, ТУЗ-ийн хараат бус гишүүн Рожер Томас Моеэс нар байна.

2024 онд Нэр дэвшүүлэх, үнэлгээ урамшууллын хорооны хурлыг нийт 2 удаа хийж, 2 асуудал хэлэлцэн ТУЗ-ийн хуралд оруулан шийдвэр гаргуулан ажилласан.

2024

1.	2024.06.26	24/88	Гүйцэтгэх захиралд урамшуулал олгох тухай
2.	2024.07.24	24/95	Нарантуяа гишүүнд цалин олгох тухай
3.	2024.09.27	24/114	Гүйцэтгэх захирлын 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийг дүгнэх

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХОРОО

Эрсдэлийн удирдлагын хороо нь Банкны үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх, хянах замаар Банкны хүлээж болзошгүй хохирлыг бууруулах, эрсдэлийн удирдлагын үр ашигтай тогтолцоог бий болгон хэрэгжүүлэхэд чиглэгддэг. Энэхүү хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Э.Бямбажав, гишүүдээр ТУЗ-ийн дарга Л.Болдхуяг, ТУЗ-ийн гишүүн Д.Моломжамц, ТУЗ-ийн хараат бус гишүүн Ж.Нарантуяа нар ажиллаж байна.

2024 онд Хорооны хурлыг танхимаар 2 удаа, цахимаар 2 удаа хийж, Банкны 2024 оны тогтворжуулалтын төлөвлөгөө, эрсдэлийн аппетит, чанаргүй активыг бууруулах, мөнгө угаах, терроризмыг болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны тайлан, Монголбанкны ерөнхийлөгчийн тушаалаар өгсөн үүргийн биелэлт зэрэг нийт 7 асуудал хэлэлцэж, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулан ТУЗ-өөр шийдвэрлүүлсэн. Хорооны ажилд гишүүд, банкны гүйцэтгэх удирдлага, багийн гишүүд идэвхтэй оролцож, банкны ажлаа гэсэн нэгдмэл зорилготой ажилласан.

2024

1.	2024.01.08	24/01	1. Эрсдэлийн аппетит гүйцэтгэл 2. МУТСТ үйл ажиллагааны 4-р улирлын тайлан
2.	2024.04.15	24/02	1.Богд банк ХК-ийн тогтворжуулах төлөвлөгөөг батлах тухай 2.Богд банкны 2024 оны 1 дүгээр улирлын эрсдэлийн аппетитын гүйцэтгэлийн тайлан 3.Богд банкны 2024 оны 1 дүгээр улирлын МУТС/ҮОХЗДС-тэй тэмцэх үйл ажиллагааны тайлан
3.	2024.06.07	23/03	Богд банкны 2024 оны Тогтворжуулах төлөвлөгөөг шинэчлэн батлах тухай
4.	2024.11.08	23/04	Богд банкны Комплаинс бодлого батлах тухай



БОГД БАНК

ИТГЭЛ ТҮГЭЭНЭ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД _____ ...

НЭР ДЭВШИГЧИД



www.bogdbank.com



Лувсанвандан БОЛДХУЯГ

Мэргэжил:

Эдийн засагч

Боловсрол:

1974-1984 онд Монгол Улс, Улаанбаатар хот, Бүрэн дунд боловсрол
1984-1985 онд Монгол Улсын Их Сургуулийн Герман хэлний анги
1985-1986 онд Унгар, Карл Марксын Их сургууль, түүх судлаач
1986-1991 онд Герман, Гумбольдтын Их сургууль, түүх судлаач
1991-1995 онд Герман улсын өмч хувьчлалын газарт судалгаа шинжилгээний ажил, их сургуулийн дадлага

Ажилласан туршлага:

1995 оноос Герман улс дахь Монголиа Хаус Файненшиал Сервисес компанийн захирал,
1996-2000 оны хооронд Голомт Банкны ТУЗ-ийн дарга, Бодь Интернэшнл группийн Ерөнхийлөгч,
2000 оноос Бодь Интернэшнл компанийн Ерөнхий захирал, Бодь Даатгал компанийн ерөнхийлөгч, Голомт Банкны ТУЗ-ийн гишүүн, СОС Интернэшнл Медика Монголиа эмнэлгийн удирдах зөвлөлийн гишүүн, Доктор. Профессор Лувсанвандан сангийн тэргүүн, Монголын Бизнес Эдийн засгийн дээд сургуулийн хүндэт доктор, Монголын гандболын холбооны дэд ерөнхийлөгч, Монголын Үйлдвэрлэгчдийн Холбооны Удирдах зөвлөлийн гишүүн,
2005 оноос Бодь Группын ерөнхийлөгч, Шведийн Вант улс дахь Өргөмжит Ерөнхий Консул,
2004-2007 оны хооронд Голомт банкны ТУЗ-ийн дарга,
2009 онд Бодь Даатгал ХХК-ийн Ерөнхийлөгч, Бодь Группын Ерөнхий захирал, Шведийн Вант улсын Өргөмжит Ерөнхий Консул, Монголын Поло Холбооны Ерөнхийлөгч, Хаан Поло Клубыг үүсгэн байгуулагч,
2011 онд Бодь Даатгал ХХК-ийн ТУЗ-ийн дарга, Шведийн Вант улсын Өргөмжит Ерөнхий Консул,
2014 онд Бодь Группын ерөнхийлөгч, Лувсанвандан сангийн тэргүүн, Лувсанвандан Арт Галерейг үүсгэн байгуулагч



Ганбаатар САРУУЛ

Мэргэжил:

Эдийн засагч

Боловсрол:

1999-2003 онд АНУ, Лоёола их сургууль, эдийн засагч

Ажилласан туршлага:

АМП Фьючерс компанийн Ази, Орос, ТУХН-ийн орнуудыг хариуцсан Газрын захирал;
2010 оноос Сангийн Яамны зөвлөх;
2011 оноос Монголын Хөрөнгийн Биржийн тэргүүн дэд захирал, вальютын захын үүсмэл хэрэгслүүд хариуцсан Ахлах трейдер;
Розентал Коллинс групп болон Мобиум Ипотекийн группд Ахлах банкир, -Бодь группын Гүйцэтгэх захирал;
Бодь даатгал ХХК-ийн ТУЗ-ийн дарга;
Богд банкны ТУЗ-н гишүүн бөгөөд Гүйцэтгэх захирал



Жамбалсүрэн НАРАНТУЯА

Мэргэжил:

Эдийн засагч, хуульч

Боловсрол:

1978-1983 онд ОХУ, Кубанийн Улсын Их Сургууль, эрх зүйч

Ажилласан туршлага:

1983-1989 оны хооронд Улсын дээд шүүхийн зааварлагч;
1989-1990 оны хооронд Сүхбаатар дүүргийн шүүхийн шүүгч;
1991-1992 оны хооронд Улсын бага хурлын зөвлөх;
1992-1998 оны хооронд УИХ-ын Тамгын газарт зөвлөх, ахлах зөвлөх;
1998-2008 оны хооронд УИХ-ын Тамгын газарт Нэгдүгээр нарийн бичиг;
2009-2010 оны хооронд УИХ-ын даргын зөвлөх;
2010-2024 оны хооронд Олон Улсын Санхүүгийн Корпорацид Хуулийн зөвлөх;



ЖАН ТОРСТЭН Дазер

Мэргэжил:

Санхүү эдийн засгийн магистр, эдийн засагч

Боловсрол:

1981-1983 онд Герман, Хамбургын Их сургууль, Эдийн засгийн бакалавр
1983-1985 онд Швейцар, Ст.Галлены коллеж, Санхүү эдийн засгийн магистр

Ажилласан туршлага:

Швейцар Улсын Солшн Партнерс Глобал ХК үүсгэн байгуулагч,
Таск Мерчант Капитал ХХК гүйцэтгэх захирал;
Бизнесийн шинжилгээ Стратегийн Свисс Партнес ХК хөрөнгө оруулалтын банкны удирдах зөвлөлийн Швейцар Улсын дижитал үйлчилгээний Глобра компанийн ТУЗ-ийн гишүүн,
Герсон Лерхман Группын шинжээч;
Бодмер капитал ХК удирдах зөвлөлийн гишүүн;



Филипп Кахен

Мэргэжил:

Эдийн засагч

Боловсрол:

1980-1984 онд Луис-Пастерийн их сургууль эдийн засгийн ухааны магистр;
1988-1992 оны хооронд Солвай бизнесийн сургууль Менежмент чиглэлээр Мастерийн дараах судалгаа;

Ажилласан туршлага:

1984-1996 оны хооронд Société Anonyme des Minerais (Англи-Америкийн корпораци), Люксембург, Лондон Санхүүгийн менежер;
1990-1996 оны хооронд IMI International S.A., Люксембург, Ром Дэд ерөнхийлөгч;
1997-2022 оны хооронд GT Satellite Systems гүйцэтгэх захирал;
1997-2022 оны хооронд Continental Finance Group S.A., Люксембург гүйцэтгэх захирал;
2009 оноос одоог хүртэл Люксембургийн Их Гүнт Улсад суугаа Монгол Улсаас Өргөмжит консул;



Рожер Томас Мойес

Мэргэжил:

Эрх зүйч

Боловсрол:

1980 – Калифорнийн их сургууль, Эрх зүй, түүх, удирдахуйн ухааны чиглэлээр Бакалавр
1988- Массачусетсийн Тафтсын их сургууль, Эрх зүй ба дипломатын чиглэлээр Магистр

Ажилласан туршлага:

-Азийн хөгжлийн банк, Меконгийн Бизнесийн санаачлага төслийн ахлах,
-Дэлхийн банкны групп/Олон улсын санхүүгийн корпорацид ОУСК Индонезий Санхүүгий хүртээмжийн хөтөлбөрийн ахлах техникийн зөвлөх, хөтөлбөрийн менежер
-FSIP төслийн (АСЕАН-ы бүс дэх FCDO-ийн санхүүжилттэй төсөл) Финтекийн ахлах зөвлөх



Базарсад ОЙГОНЖАРГАЛ

Мэргэжил:

Эдийн засагч

Боловсрол:

1999 - 2001 Санхүү эдийн засгийн их сургууль, Банк зээлийн эдийн засагч - Санхүүч
2006 - 2008 Удирдлагын академи, Удирдахуйн ухааны магистр

Ажилласан туршлага:

2004 - 2020 Жем Интернэшнл ХХК, Ерөнхий захирал
2020 - одоог хүртэл Жем Интернэшнл ХХК, Ерөнхийлөгч



Рэнцэндорж БАЯСГАЛАН

Мэргэжил:

Бизнесийн удирдлага

Боловсрол:

1996-2001 онд МУИС-ийн Эдийн Засгийн Сургууль, Эдийн засагч;
2015-2016 оны хооронд Оксфордын Их сургууль эдийн засгийн ухааны магистр;

Ажилласан туршлага:

2001 - 2002 Хаан банк - Зээлийн мэргэжилтэн
2002 - 2009 Монголбанк - Ахлах эдийн засагч
2009 - 2011 Азийн хөгжлийн банк - Эдийн засагч
2013 - 2014 Олон улсын Валютын сан - Ахлах судлаач
2014 - 2018 Олон улсын Баялагийн Сангийн Форум - Ахлах менежер
2019 - 2021 Милкен Институт - Захирал
2021 - 2022 Хүртээмжийн Капитализмын Консул - Захирал
2022 - Одоо Дэлфос Интернэйшнл - Зөвлөх



Дэмчигжав МОЛОМЖАМЦ

Мэргэжил:

Эдийн засагч, Доктор профессор

Боловсрол:

1970-1975 онд ОХУ Санхүү эдийн засгийн бакалавр, Улс ардын аж ахуйн дээд сургууль
1985-1987 онд ОХУ Эдийн засгийн дэд доктор, Санхүү эдийн засгийн сургууль
1997-1999 онд ОХУ Эдийн засгийн доктор цол, Санхүү эдийн засгийн сургууль

Ажилласан туршлага:

1975-1990 оны хооронд Сангийн яаманд Монгол Улсын Сангийн сайд, Төсвийн газрын дарга, Валютын газрын дарга,
1990-1992 оны хооронд Монгол Улсын Засгийн газарт Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга,
1992-1996 оны хооронд Монгол Банкны Ерөнхийлөгч,
1997-2001 оны хооронд Эдийн Засаг Хамтын Ажиллагааны Олон улсын байгууллагад Орлогч дарга,
2012-2016 оны хооронд Олон Улсын Хөрөнгө Оруулалтын Банканд Орлогч дарга

Саналын хуудасны хавсралт

Богд банкны 2024 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.6, 29.2.7, Богд банкны дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.3, Богд банкны 2024 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 2025 оны 04-р сарын 03-ны өдрийн №..... тоот шийдвэрийг тус тус үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ нь:**

1. Богд банкны 2024 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн “.....” гэх дүгнэлтийг зөвшөөрч баталсугай.
2. Энэхүү хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийг холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлж нийтэд мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Л.БОЛДХУЯГ

Саналын хуудасны хавсралт

Богд банкны ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны тайланг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн, 62.1.15, 62.1.16, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.6, 29.2.9, Богд банкны дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.8, 7.8.9, Богд банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлан, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 2025 оны 04-р сарын 03-ны өдрийн №..... тоот шийдвэрийг тус тус үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ нь:**

1. Богд банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайланг гэж дүгнэн баталсугай.
2. Энэхүү хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийг холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлж нийтэд мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Л.БОЛДХУЯГ

Саналын хуудасны хавсралт

Богд банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн, 62.1.7, 75 дугаар зүйлийн 75.1, 75.4, 77 дугаар зүйл, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.9, 31 дүгээр зүйлийн 31.2, Богд банкны дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.1, 8 дугаар зүйлийн 8.2, 8.3 дахь заалт Богд банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 2025 оны 04-р сарын 03-ны өдрийн №..... тоот шийдвэрийг тус тус үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ нь:**

1. Богд банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр:
 - 1.1.
 - 1.2.
 - 1.3.
 - 1.4.
 - 1.5.
 - 1.6. нарыг 3 жилийн хугацаатайгаар томилсугай.
2. Богд банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр:
 - 2.1.
 - 2.2.
 - 2.3..... нарыг 3 жилийн хугацаатайгаар томилсугай.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Богд банкны дүрэмд заасан эрх, үүргээ хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгосугай.
4. Энэхүү хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийг холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлж нийтэд мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Л.БОЛДХУЯГ

Саналын хуудасны хавсралт

Богд банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсвийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн, 62.1.13, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.9, Богд банкны дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.7 дахь заалт, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 2025 оны 04-р сарын 03-ны өдрийн №..... тоот шийдвэрийг тус тус үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ нь:**

1. Богд банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсвийг энэхүү шийдвэрийн хавсралтаар баталсугай.
2. Энэхүү хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийг холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлж нийтэд мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Л.БОЛДХУЯГ



БОГД БАНК

ХУВЬЦААТ КОМПАНИ



Богд цамхаг - 4-н давхар, Жигжиджавын гудамж,
Чингэлтэй дүүрэг, 1-р хороо,
Улаанбаатар 15160, МОНГОЛ УЛС

Утас: +976 7577 1199
Факс: +976 11 328311
Вэб: www.bogdbank.com
И-мэйл: info@bogdbank.com